

2015 оны 10-р сарын 3-4-ний өдрүүдэд Баян-Олгий аймгийн ЗДТГ, Байгаль Орчин Аялал Жуулчлалын газар, Монгол Алтайн нурууны УТХГХЗ, Монголын Бүргэдчдийн Холбоо хамтран уламжлалт "Хыран 2015 Бүргэдийн баяр"-ыг 16 дахь удаа Баян-Олгий аймгийн Бугат сумын "Саят толгой" хэмээх газарт зохион байгуулах гэж байна.

Уг наадмын зорилго Казахстан ард түмний эртнээс уламжилж ирсэн бүргэдээр ан хийх арга ухааныг хойч үед овлүүлэх, сурталчлах, хөгжүүлэн дэлгэрүүлэх, аялал жуулчлалын шинэ брэндийг бий болгон хөгжүүлэх, ард иргэдийн байгаль орчныг хамгаалах, нохон сэргээхэд оролцох оролцоог нэмэгдүүлэх, ходоо орон нутгийн жуулчны баазуудын вйл ажиллагааг дэмжих, орлогыг нэмэгдүүлэх юм. Энэ жил "Хыран 2015" наадам нь Монгол төрийн оролцоотой зохион байгуулагдах бөгөөд аймгийн 12 сумын бүргэдчид жагсаж үзүүлэх тоглолт хийх юм.

Тус баярын үеэр дараах арга хэмжээнүүд зохион байгуулагдах юм.

Үүнд:

- Бүргэдчид бүргэдээ анд сургасан байдлыг шалгаруулан дүгнэх /"Шырга тарту"/
- Тэмээний уралдаан
- Дааганы уралдаан
- Казах үндэсний "Кыз Куар" тоглоомын үзүүлбэр
- Үндэсний "Кокбар" буюу тулам булаалдах тэмцээний үзүүлбэр
- "Тенге илу" буюу морин дээрээс монго шүүрэх тэмцээн
- Казах үндэстэний шилдэг хувцастай хос шалгаруулах тэмцээн
- Урианхай сурийн харваа